# Чимээгүй нулимс

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Чимээгүй нулимс
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

# *Аниргүйхэн нулимс*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Ади Шанкара



Гүрү Нанак



Есүс Христ

# Эхлэл

## Дотоод Багш:

Цаглашгүй амьдралын бэлгэ тэмдэг!
Энэрэл нигүүлслээр оршихуйн бүхнийг адислагч
Эгнэшгүй хүчит Түүнийг зарим нь
Эцэг минь, Ижий минь гэж дуудна,
Аливаа бүхний эхлэл, ивээлт Бурхан минь гэж өргөмжилнө.
Дээдийн зам мөр минь гэж зарим нь нэрлэхэд
Дэврүүн сэтгэлээр зарим нь үзэсгэлэнт сүйт бүсгүй минь,хайрт минь хэмээнэ.
Зарим нь өчигдрөөс өмнө байсан өөрийн чинь жинхэнэ төрх гэнэ.
Зарим нь агуу суу билиг, төгс төгөлдөр зам мөр, хайр гэнэ.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Шагжамүни Будда

Зөнч Мухаммед

*Үгсэж Түүнийг аль дуртайгаараа нэрлэ.*
*Үнэндээ Тэрээр өчүүхэн ч дургүйцэхгүйгээр*
*Тэр хэн, юу байх нь хамаагүй хэрэг.*
*Түүнгүйгээр л амьдарч үл чадмой.*
*Түүнтэй учрах мөрөөдөл бол хамгийн бэрх хүслэн.*
*Тэр ямар зовлонтойг шидэт Даогийн замаар явагсад л мэднэ.*
*Эгээрэл биелж, Түүнтэй учрахын цагт*
*Энэхэн хорвоод дүйцэх зүйлгүйг ухаарна.*
*Гэрэл аялгууг хөлөглөн одох*
*Гэгээрлийн зам өмнө чинь байна.*
*Энд, энэ л агшинд үүдээ нээх*
*Энхжингийн орон дотоодод чинь байна!*

Багш бол сайхан сэтгэлээс ч илүүтэй.
Нөхөд минь ээ, Түүний хязгааргүй их нигүүлслийн тухай
Ярья гэхэд цаг ямагт хомсдоно.
Яахав дээ, сэтгэлийнхээ мухарт л
Ядмагхан би хайрын нулимс бөмбөрүүлж сууна.
Хайр ба нигүүлслээр түүн шиг дүүрэн нь
Хан хорвоод нэгээхэн ч үгүй.
Олон төрөлдөө хараацай шувуу болоод
Ойчилгүй өрөөсөн хөл дээрээ зогсон
Онцгой Түүний алдрыг магтан дуулах нь
Олдошгүй завшаан болохсон билээ надад!

Багш минь ээ,

Би Тандаа хайртай.

Гагцхүү өөрийнхөө төлөө огтхон ч биш шүү.

Гараг эрхсийн оршихуй бүхний тусын тулд шүү.

Таны ивээл таалалд багтан

Амьтан бүхэн амар амгаланг олох болтугай!



Тэнгэр газрын эзэн Багш минь ээ!
Тэнсэлгүй хайрын Бурхан минь ээ!
Зовлон жаргалаас хэтийдсэн Та
Зүрх сэтгэлийг минь эзэмдэнэ билээ.
Таны сорилтыг давна гэдэг ч бэрх л дээ.
Та минь намайг энэ л байгаагаар минь
хүлээн авна уу?
Тангүйгээр харанхуй энэ орчлонд амьдарна
гэдэг ямар шуу байхыг
Та бэлхнээ мэдэж байгаа билээ.
Та минь л гараас барихгүй бол
Би тэр дороо л унах болно.
Би үүнийг сайн мэдэж байна.
Битгий л тэгж үзээрэй Багш минь!

Үнэндээ зөвхөн Таныг л би эрхэмлэн дээдэлнэ.
Үүнийг Та аль хэдийн мэдсэн байж таарна.
Эрхэм нэр алдар
Энэ хорвоогийн жаргал цэнгэл гэдэг
Хамгийн хэрэггүй тэр бүхнийг
Харин яагаад над руу илгээнэ вэ Та...?
Эдгээр нь бүгд Танаас ирүүлсэн бэлэг учраас л
Би хүлээн авах болно.

Гагцхүү Тандаа л хайртай гэдгийг
Сайн санаарай Багш минь!

Бүхий л хорвоод Та гэрлээ тусгасан ч
Ганцхан намайг л харанхуйд орхих юм.
Тэр харанхуйг дуусан дуустал зүрх минь шаналан зовно.
Тэр ч Танд хамаагүй л байх
Таныг хаа сайгүй л оршдог гэх юм Багш аа,
Та яагаад миний гэрт хөл тавьдаггүй юм бэ?
Хөөрхий миний нүдний өмнүүр
Хөшиг татаастай санагдах юм.
Жаргалтай хорвоогийн Бурхан минь ээ!
Зайлуулж өгөөрэй, энэ хөшгийг, мөргөн гуйя!
Өршөөлт Таныхаа нүүр царайг нэг харахсан
Өнө мөнхийн амьдралд умбахсан!
Амитаба минь ээ!


БАГШИД ҮРГЭЛЖ
НЭЭЛТТЭЙ
24 ЦАГ НЭЭЛТТЭЙ
БАГШ ТА ТАВТАЙ МОРИЛООРОЙ
БИЧНИЙ МАЙХАН



Гүрү Нанак

Төгс төгөлдөр нэгэн биш гэдгээ би мэднэ.
Тийм хүн гэж байхгүй гэдгийг бас хэлж чадна.
Хайрт багш минь битгий л их хүлээлгээрэй,
Харанхуйн ёроолоос намайгаа татан гаргаарай гэж
Тандаа залбирья!
Гэрэл гэгээндээ намайг умбуулж хайрлана уу?
Цаглашгүй нигүүлсэлдээ багтааж болгоно уу?
Багш минь ээ! Та минь сонсож байна уу, үгүй юу?
Сонсож л байж таарна.
Миний аргаа барсан залбирлыг
Огоорч сонсоосой гэж бодохдоо...
Маргааш би хүмүүний хоёр чихийг
Олж өгье дөө Тандаа.


ЦАГТ 10.000 БЭЭР

Шантай уулзахын хуслэн болж
Өглөөжин ганцаараа суулаа.
Та минь хүрч ирсэнгүй,
Өдөржин ганцааараа суулаа.
Хамаг дэлхий миний хүслэнг мэдэх юм.
Харин Та л ганцаараа анзаарч үл тоох юм.
Сүүмэлзэх дэнгийн гэрэлтэй харанхуй өрөөнд
Шөнөжингөө би сэрүүн байлаа.
Харин Таны гэрэл гэгээ л
Хаанаас ч тусч гийсэнгүй ээ!
Хүссэн зүг рүүгээ яв даа, Багш минь!
Залхаж би гуйцгээ.
Зүрх минь одоо шархаллаа.
Тэсье гэсэн ч иг
Тэвчээр хүрэхгүй нь ээ.
Үхэх төрөхийн учиртай төрсөн
Хүмүүн гэдгийг Та мэднэ.
Би явлаа!

Жич: Маргааш болтол баяртай.



Шанд бол үй олон шавь нар байна.
Надад бол ганцхан Та минь л байна.
Та бид хоёрын хэн нь илүү үнэнч байна даа?
Үнэндээ би өөрийгөө өрөвдөж байна!
Үнэндээ би гомдож байна!
Намайг сонсож байгаа амьтан байна уу?
Дэлхий хорвоог огоорохгүй
Цэнгэл жаргалыг тоохгүй байгааг минь ч
Багш минь та огтхон ч анзаарахгүй байна.
Уусан идсэн ч Түүнээс болоод амтгүй санагдана.
Унтах нойр минь шөнөжин бас хулжина.
Ойшоож Багш нь тоохгүй байна уу? гэж асуувал
Огтхон ч үгүй гэж би хариулах байна!



Багш минь Та хүмүүний нүдээр харахаа мартсан бололтой
Бурханы мэлмий тань л ямагт хараад байна уу даа.
Тантай учрахыг хүсэн өрөөнийхөө буланд ганцаардан суугаа минь
Тийм л учраас Та минь харахгүй байгаа юм байна.
Дээд ертөнцийн алдар хүндийг эдлэн байгаа Танд
Доод оршихуйн харанхуйд тарчлан байгаа би ч
Ямар хамаатайсан билээ.
"Үлэмж төгөлдөр" гэгээнтэн минь ээ!
Үзэж хардаг мэлмийгээ яагаад гээчхэв дээ?
Танд би нүдээ баяртайгаар бэлэглэе!
Та өдөржин шөнөжин хэрэглээрэй.
Эрхэмсэг сайхан дүрийг тань олж нэг харахын тулд
Ганцаар сажлан үйлээ үзэж яваа минь
Ганцхан хором ч бол та хараасай даа!



Хорвоогийн дурлагсад хүртэл миний сэтгэлийг өрөвдөх биз,
Харин та ч тоохгүй л дээ,
Энэ хорвоогийн хайртнууд хүссэн цагтаа учирдаг байх.
Эрхэм Таны хаалга бол үргэлж л хаалттай байх юм.
Зориод очих бүрт жихүүн хүйтэн
Цоож цуурга л өмнөөс угтана.
Татаастай хөшигний цаана бүдэгхэн гэрэл байвч
Таны минь царай хэзээ ч үл харагдана.
Ордондоо заларч байгааг тань би мэдэж байна.
Онгойлгож л чадахгүй юм даа хаалгыг тань
Одоо харин нэг л өдөр
Онцгой том сүхтэй л ирэхээс дээ!



Эртийн эрт цагаас
Эцэс төгсгөлгүй үргэлжлэх
Нэг нь нуугдаж,
Нөгөө нь олдог тоглоомоор
Тоглохын ашиг нь юу юм бэ? Багш аа!
Тэнэг цэцэн үй олон хүмүүс
Иймд тоглоомоор тоглож эрч хүчээ баржээ.
Би ч болъё доо!
Хэрэв Та нэгэн өдөр залраад ирвэл
Би оршин байх хүч чадалгүй болчих нь шүү дээ!
Чингэх нь Та бидний хэнд ч хэрэггүй
Тийм болохоор энэ тоглоомыг зогсооё!
Би зүрх сэтгэлээ нээгээд
Таны үүдэн дээр ухаангүй хэвтэж байна шүү!
Хажуугаар өнгөрөгсөд
Харж л байна даа хөөрхий намайг.
Харин Та ч үгүй л юм даа.
Хайр энэрлийн Эзэн Бурхан минь ээ!
Хайрлаж сэтгэлд минь амьдралын рашаан дусаагаач,
Хэрвээ хурдан дусаахгүй бол
Хэзээ ч би сэрэхгүй нь байна шүү!




Бурхан Багш минь ээ!
Танай гэрт хүрэх зам
Дан чулуу, дан өргөс
Гэтэл би замын талыг туулав.
Гэдрэг буцах нь бүр ч бэрх болов.

Диваажинд хүрэх замдаа
Хайрлах зүрхээ
Хаа нэгэн газар гээсэн юм биш биз, Та!
Тэгээгүй юм бол
Та миний сэтгэлийг мэдрэхсэн.
Миний зүрх ч энгэр дээрээ ил л байдаг шүү!
Таныхаа төлөө тахисан ч яахав дээ!

Хамгаас хайрт Багш минь ээ,
Хүмүүний зүрхээ гээсэн юм бол Та
Минийхийг оронд нь ав л даа.
Чингэвээс та нэгэн завин дээр хөвж яваа нөхдийг минь
Мэдээд өрөвдөх байлгүй дээ.
Сансрын хурдийг л тэд мэддэг юм.
Санаж зорьсон газар нь Нирваан юм шүү.



Би амьдралын цөлд цангаж явна.
Та бол диваажинд морилон
Амтат рашаан шимж байгаа.
Хэрвээ би хүрэх замыг нь мэддэгсэн бол
Дээш огоод шуудхан л шуурэн авахсан.
Алдар хүндийн оройн дээд Багш минь
Надад хэдхэн дуслыг хайрлавал
Шударга гэж бодохгүй байна уу даа?



*Өөрийгөө би Танд даатгасан шүү дээ.*
*Өнө мөнхийн амьдрал, ашдын жаргаланг*
*Та ч надад амласан.*
*Үгнд чинь би итгэж байна.*
*Үнэн голоосоо найдаж байна.*
*Өршөөлт Багш минь тэр бүхнээ*
*Үтэр түргэн биелүүлж хайрла!*
*Үгүй бол харанхуйн хунтайжийн мөрлэнд*
*Өчүүхэн шавь чинь амьсгал хураах нь!*

Та тэнгэр газрыг нүүлгэж чадна,
Та бүр чөтгөрийг хайрын сахиусан тэнгэр ч болгож чадна.
Ид шидтэний агуу их Эзэн минь ээ!
Ийм нэгэн бичний оюун санааг юунд эс өөрчлөв?

*Хэрэв Та намайг хайрлахгүй бол*
*Хэнийг ч би энэ хорвоо дээр хайрлаж чадахгүй.*
*Мэднэ ээ мэднэ, Багш та аль хэдийн*
*"Оршихуй бүхэн бүгдээрээ Бурханы бүтээл"*
*гэж хэлсэн билээ.*

*Хайрт Багш минь,*
*Та надад Бурханаас ч илүүтэй билээ.*



Хэрэв Та надаас нүүр буруулбал
Бурханы хэрхэхээ би мэдэхгүй байна.
Цорын ганц шүтээн минь ээ,
Энэрлийн гэрлээ харамгүй хайрлаач!
Түүнгүйгээр надад амьдрал үгүй.
Өнөө муу шавьд нь Танаас өөр
Өмөг түшиг ямар байх биш.


Есүс Христ
Гүрү Нанак
Шагжамүни Будда
Ади Шанкара
Зөнч Мухаммед

*Үхэл амьдралын эцэс төгсгөлгүй хүрдэнд*
*Үйлээ үзэн зовж байгаа*
*Дуулим хорвоогийн хамаг амьтныг төлөөлөн*
*Дуу хоолойг нь сонсгох гэсэн юм.*
*Тэдний зовлонг үтэр түргэн дуусгаж өгөөч ээ, гэж*
*Нигүүлсэнгүй Багш Танаас залбиран гуйя!*



Есүс Христ

*Хорвоо ертөнц гэдэг бол*
*Хорсон шунаж, хилэгнэн хатгагч*
*Хорт могой, хилэнцэт хорхой дүүрсэн*
*Гүн эргүүлэг юм.*
*Хүн зон тэнд олноороо*
*Хөөрхийлөлтэйгээ живж байна.*

*Хаадын хаан Багш минь ээ,*
*Хайрлаж тэднийг өршөө!*
*Энхийн ордонд нь эгүүлж хүргэнэ үү?*
*Мөнхийн хаврыг тэдэнд сэргээж өгнө үү?*

Та хэн нэгэн дээр ялдамхан харцаа тусгахад
Тэр өөрийгөө зөвхөн Таны хайрт гэж итгэх болно.
Хайрын дээд Хайр минь ээ,
Харцаа над дээр тумэнтээ тусгаач!


БҮХНИЙГ ИХ БАГШДАА...ЛА...ЛА ЛА...
АГУУ ИХ БАГШ
ИХ БАГШ ТҮМ НАСЛА
ИХ БАГШ

Багш минь ээ,

Татаад нээнэ үү? далдлагч хөшигийг.
Та л гагцхүү чадахсан билээ.
Хүчтэний дээд хүчтэн Та минь,
Хүлцэж юунд эргэлзэнэ вэ?


大拍賣
ЗӨВ СОНГОЛТ
ХЯТАД ХОРООЛОЛ
SPECIALITE
DE LA MAISON
À LA CARTE
НЭРИЙН ХООЛ
ХУДАЛДАА
50% ХЯМДРАЛ

Хосгүй сайхан харцыг тань худалдан авахын түлд
Хорвоогийн наран саран бүх оддыг зарах юмсан.
Цаглашгүй гэрэлт Багш минь,
Хүсэн хүлээсэн зүрхэнд минь
Өршөөж хэдхэн цацраг тусгана уу?




Багш минь ээ,

Тантай нэгэн зүйлийг тохиролцмоор байна.

Түрхэн зуурдаа хоёулаа байраа сольё!

Танаас ангид байх ямар хэцүү болох

Төсөөлшгүй бэрхийг мэдэх болно, Та тэр үед.

Хамаг бүтээлийн Эзэн минь ээ,
Харж үзэв үү? Та миний хувь заяаг.
Хэтэрхий их ачааг Та надад үүрүүлж
Хэрэггүй юмсаар нуруug минь хотойлгов.
Уулын оргил өөд мацаж явахад
Урдаас чулуу өнхрүүлэх юм даа.

Багш минь ээ! Багш минь!
Хурдхан намайг авраач!
Эс тэгвээс би чинь
Энэ хачин Бурхантай чинь хамт л
булагдах нь байна шүү!

Хаана Таны нуугдаж байгааг мэдэх л юм бол
Хайхаар би чинь хурдхан очно.
Халаг, чаавaac хараагүй төрсөн юм би.
Халил оргилд хүрэхийн аргагүй.
Дуудъя гэвч хэлгүй шүү дээ би,
Дууг чинь сонсъё гэвч дүлий шүү дээ би.
Багш минь ээ,
Ийм хөөрхий амьтныг та л бүтээсэн биз дээ.
(Тэгж л хүмүүс хэлээд байх юм)
Түүнийгээ огоорч нэг үз л дээ!
Тэгэхгүй бол ганцаараа гутамшигтай төгсөх нь байна.
Та үүнийг маш сайн мэдэж байгаа шүү дээ!

*Та мэлмийтэй билээ,*
*Намайг ирж харна уу?*
*Та амтай билээ,*
*Намайг дуудаж ярина уу?*
*Та чихтэй билээ,*
*Миний хуслийг сонсоно уу?*
*Бурхан минь ээ,*
*Тэр их диваажиндаа Та минь ганцаар юу хийнэ вэ?*
*Тэндээ уйдахгүй байна гэж үү?*

Хорвоо гэдэг гамшиг зовлонгоор дүүрэн,
Хөөрхий миний сэтгэл Танаар дүүрэн.
Дэлхий хорвоод Та минь заларвал
Дэндүү бэрх бүхнээс бид хагацах болно.
Зовлон шаналлаар дүүрэн энэ орчлонд
Залрах зай Танд минь алга даа!

# АВШИГ




Хорвоогийн хүмүүс гэрлэхээрээ
Хүсэл нь намжиж дарагдах болно.
Харин би тантай учраад
Хамаг хүсэл минь бадарч эхлэв.



Ивээлт Багшийн минь ХАЙР зүрхэнд цутгахуй
Идрийн жавхаа гийж, шинээр би төрнөм.
Учир шалтгааныг надаас асуух хэрэггүй,
Ухаан бодлоор цэгнэж болох ХАЙРын учиг энэ биш!

*Ная хурсэн нэгний нуд нь цогтой гэрэлтэж,*
*Насан залуугийн жавхаагаар гялалзахтай таарвал*
*Багшийн шидэт мутраас адис хуртжээ, гэж*
*Бат итгэж болно, номын ахан дуус минь!*

Та минь энэ хорвоог хайрлахыг надад заалж сургасан билээ.
Тангүйгээр би Хайрын үнэн мөнийг хэзээ ч мэдэхгүй байсан.
Харин үүнийг бусдад би хэлэхгүй,
Ухаанаа гээсэн хэмээн намайг тэд бодох болно.
Угтаа би чинь тэнгэрийн рашаандаа хөлчүүрээд байна аа.



Хайрт Багшийнхаа тухай бодохоос ч өмнө
Харах нүдэнд минь нулимс бүрхэх шиг болох юм.
Эгч нар минь яагаад гэдгийг нь мэдэж байна уу?
Үүний учир нь Багш намайг бодолдоо ямагт тээдгээс тэр.

*Таны минь яруу найраг, Багш минь,*
*Миний сэтгэлийг хамгийн ихээр хөглөнө.*
*Яагаад гэвэл хайрт Багш минь,*
*Сэтгэлийн минь гүн дэх хамаг нууцыг*
*Та илрүүлдэг болохоор л тэр шүү дээ.*

Машид яруу шүлгийг тань уншаад
Мянгантаа би урамшлаа.
Дундаршгүй хайрын тань аялгууг
Дуулим хорвоо дуулсаар байнам.
Эрхэм найрагч Багш минь Та
Эгэлгүй ертөнцийг бүхлээр нь
Гэгээн сэтгэлээрээ уярааж чадна аа.


THE OLD TIME
The Old Time
THE SUPREME MASTER CHING HAI
PEBBLES AND GOLD
Pebbles and Gold
THE SUPREME MASTER CHING HAI
TRACES OF PREVIOUS LIVES
Traces of Previous Lives
THE SUPREME MASTER CHING HAI
THE LOST MEMORIES
THE SUPREME MASTER CHING HAI
The Lost Memories
Silent Tears
WU TZU POEMS
Wu Tzu Poems
THE SUPREME MASTER CHING HAI



Өглөөд хүмүүс босоод
Наран мандахыг ажиглана.
Үдэш болохоор тэд
Хязгааргүй огторгуйн дундах сар болон оддыг ажиглан баясна.
Харин миний нүд ямагт
Таны гэгээн дүрийг л ажиглана.

Хань ижил минь намайг хаявал
Арай ядан би амьдрах байсан.
Үр хүүхэд минь намайг орхивол
Гарцаагүй би уйлах байсан.
Уудам дэлхий намайг хаявал
Уйтгар гунигтай л явах болно.
Хайрт Багш минь намайг огоорвол
Харин миний амьдрал төгсөх болно.


師
ИХ БАГШ + БИ
DEEP SECRETS FROM
THE MONK + THE MONKEY
ИХ БАГШ + БИ
ИХ БАГШ + ШАВИЙН
ДАЛД НУУЦУУД
徒
MASTER + I
祕
密
БИЧНИЙ ДАЛД НУУЦУУД

Хорвоогийн хүмүүст би
Хоёр биенийхээ нууцыг нээхгүй.
Зүгээр л тэр нууцаа гэрэлтдэг дэр болгоод
Зүүднийхээ ертөнцийг чимэх байсан.



EGO
THE GREAT
EGO
БИ ҮЗЭЛ
МАШ ИХ
大我
БИ ҮЗЭЛ
EGO
大我
БИ ҮЗЭЛ
EGO
EGO
THE GREAT
EGO

Амьдралын турш үйлчилж
Амьдралаа зориулахын тулд
Таны гэгээн гэр бүлд би нэгдлээ.
Миний мэддэг юм гэж өчүүхэн,
Таны болзол тун ч өндөр юм даа.
ӨӨРИЙГӨӨ гэх үзлээсээ ангижир гэлээ.


TO MONKEY WITH LOVE
HONEY PIE
ХАЙР
АЛИМ
CANDY

Мянган чигбээрийн цаанаас
Таныхаа нигуулсэнгүй дүрийг үзнэм,
Тавируулах хайрыг мэдэрнэм.
Хаа сайгүй оршигч Та минь
Хамаг ертөнц юм даа, хөөрхий.


Яваач!
АСУУДЛУУДАА
БИ ХАЙРТАЙ

Замбуулингийн хүмүүс хэрхэн Таныг хайрлахыг
мэддэгсэн бол
Зовлон гуниг нь арилах байсан.
Харин зовлон гунигтаа тэд дуртай нь
Харамсалтай юм даа хайрт Багш минь!


ӨДӨР БҮР ИХ
БАГШИЙН
❤ ӨДӨР
НУЛИМСНЫ САВ
ҮНЭТ ЭРДЭНЭС
АЛТ

Би гэдэг хүн элий балай ч болсон юм шиг!
Таныхаа төлөө аниргүйхэн бөмбөрөх нулимсаа би
Хорвоогийн очир алмасаас ч илүүтэй хайрлан суух юм.
Насны хүслийг хангагч эрдэнэсийн Хаан минь ээ,
Надад өөр сонголт байна гэж үү дээ?


100%
БИЧНИЙ ҮНЭН

*Хүмүүс амархаан худал хэлэх юм.*
*Тэднийг дууриайгаад үздэг ч байж уу?*
*Тэгэхэд ганц л зовлон байх юм даа.*
*Үнэндээ амаа дөнгөж л нээмэгц*
*ҮНЭНий бөмбөлөг өөрөө л урсаад гарчих юм.*

Зөнч Мухаммед

*Одод ч хүртэл заримдаа нойрсохоор одоход*
*Огтхон ч унтахгүй би ямагт л сэрүүн байдаг.*
*Та миний сэтгэлд гэгээн хүслийг бадрууллаа.*
*Та бид хоёр алжаахыг мэдэхгүй боллоо.*

Үргэх, жаргах өөрийн цагтай билээ, наран саран
Улиран ээлжлэх жамтай билээ, дөрвөн улирал
Үргэлж хувирах чанартай билээ, тэнгэр хангай
Үлэмжийн хүсэл минь яагаад эс төгсөнө вэ?!

Ариун эцэг минь ээ!
Энэрэнгүй Будда минь ээ!
Бүх л орчлонгийн
Бүхнийг чадагч Багш минь ээ!
Амьдралын аян удахгүй дуусаасай гэж залбирнам.
Алжааж ядарсан ноорхой хүү чинь
Ачтай Таныхаа болзолгүй хайрын
Ариун булагт ахин шумбах болно.

Өдгөө бол,
Өдөр нь өнө удаан үргэлжилж
Шөнө нь үүрдийн юм шиг санагднам.





Их Багш Чин Хай 1980-аад оны эхээр гэрийн эзэгтэй байхдаа
Тайландын мөргөлийн сүмд

*Дарангуйлж, намайг үл тоогч хэний ч гэсэн сэтгэл нь*
*Түмэн нарны гэрэлтэй нигүүлслийн буянаар,*
*Түүнчлэн ирсэн Таны ганц үсний гэгээн ивээлээр*
*Түргэн зуур амарлин дэлгэрээсэй гэж мөргөе!*


福
福 田
Хүмүүний буян хишиг, сайн үйлсийн талбар

Гайхамшигт Багш минь ээ,
Та далай руу харцаа тусгахад
Бүх загас тэнгэрийн луу болоод
Үүлэн өөд нисэн одно.
Хүмүүний сайн үйлийг тэтгэн дэвжээж
Ивээлийн хур цутган бууна.

Таны мутар хүрсэн чулуу бүхэн алт болж
гялалзана.
Чөтгөр шуламс бүгдээрээ бурхан болж хувирна.
Бүхнийг чадагч Багш минь ээ, Танд мөргөе!
Таныг хүрэх төдийд миний сэтгэл
Таных л болж хувирах юм.


ОМ
М
ЧУЛУУ
АЛТ

Таны адислал гэдэг
Сайн муу, сайхан муухай,
Онцгой хийгээд олигүй
Олон амьтныг адилхан ивээнэм!
Багш минь ээ,
Таны алдрыг магтаж баршгүй ээ.
Таны хайрыг элгэндээ тэврэн
Тавтай нойрсъё доо орой бүр.

Шантай байсан мөч бүхэнд
Тайван амгалангийн дээдийг үзэх юм.
Бүх хүмүүн хийгээд сахиусын Эзэн минь ээ,
Бүр эртний гайхамшигт ариун рашаанаасаа
Ахиад нэгээхэн удаа
Амсуулж хүртээнэ үү?



Ади Шанкара

Би гэдэг мунхаг амьтан
Бурхан Будда болох гээд
Төгс төгөлдөр Багш,
Багш ламтан,
Бас Махаража болох гээд зүтгэнэм.
Энэ бүх ачааг нуруун дээрээ юундаа ч үүрнэм?
Энгүй Таны дэргэд байх хайран цагаа юундаа ч үрнэм?
Ухаантны дээд Ухаантан минь ээ,
Ямар ч үүргийг надад өгсөн
Аминаас минь үнэтэй байлаа ч гэсэн
Амжуулж хийхийг би хичээнэ.
Үнэхээр би тэгнэ шүү!
Үнэндээ танд барих өчүүхэн өргөл минь тэр юм шүү!



Таны тухай бодох бүрийд
Миний бодол найраг болж урсана.
Гоо үзэсгэлэнгийн төгс дээд Багш минь ээ,
Үүний учир нь таны Аялгуу миний сэтгэлд
ямагт дүүрсэн.

Таны мөнхийн хайр энэ дэлхийд үгүйсэн бол
Хараацай шувуу хаврыг ч үл анзаарна.
Оройн дээд Багштан минь ээ,
Таныг БАЙХАД Л би мөнхийн хаврыг мэдрэх юм.




Хорвоогийн дурлалд умбагсад өөрсдийгөө
хайрыг сайн мэддэг гэж бодох юм.
Хаанаас даа! Тэд эндүүрч байна.
Харин Багш бид хоёрын холбоог тэд
мэддэг ч болоосой!

Чаны гэгээн өлмийд сөгдөн цагийг өнгөрөөх нь
Миний амьдралын хамгийн дээд жаргал.
Ахиад нэг тийм адислал хүртэхийн тулд
Аливаа бүхнийг огоорохад би бэлэн.




Хорвоогийн хүмүүс оройдоо
Ертөнцийн гэрэлд умбаж, хөгжимд нь саатан
Дуулж бүжиглэхээр гарч байна.
Би л ганцаар гэрэл аялгуунд умбан,
Бясалгалдаа цэнгэн суунам.

Эрхэм тансаг яруу алдрыг тань таньж мэдсэнээс хойш
Энэ хорвоогийн юунд ч би үл татагдана.
Багш Та намайг хайр ивээлдээ багтаан
Мөнхөд нигуулсэн болгооно уу!




Их Багшийн зурсан зураг: Сүр жавхлант толгод

Master's Painting

Хорвоогийн дурлалд умбагсад өөрсдийгөө
Хайрын зовлонг мэднэ гэж бодох юм.
Халаг, чаавaac! Юутай төөрөгдөл вэ!
Таныг мөрөөсөн зовж байгааг минь мэддэг ч болоосой.

Таныг магтсан нэг ч үг
Дахин хэлэхгүй гэж би андгайлсан ч гэсэн
Хүмүүний үг, ярианы баялаг ямар ч ядмаг юм бэ дээ?
Таны гайхамшигт сүр жавхланг
Илэрхийлэн хэлэх үг олдохгүй байгаад
Үнэхээр ичгүүртэй санагдаж байна.

Таныг залран ирэхэд
Нарны гэрэл ч суумийх мэт.
Таны оршин байгаа нь
Түмэн одод, тоолж баршгүй эрдэнэс гялалзах мэт.
Таны гэгээн эрхэмсэг залуу төрх тань
Миний сэтгэлийн харанхуй мухрыг гэрэлтүүлнэ.
Таны эрхэм дээд гоо сайхан бол хамгийн нандин урлаг.

Амьгүй цутгамал бурхадыг
Ахиад шүтэж би яасан ч чадахгүй ээ!
Зурсан хөрөг хэчнээн агуу ч
Зуйрлэж яахан болохсон билээ.

Баяр цэнгэлээр халгиж цалгисан
Сэтгэлийн хайлан минь ээ!
Таны цог жавхланд умбан байхад
Гэгээн баяртай.
Харин хамаг зовлон гуниг
Хаашаа ч юм алслан одно.



Богд их мэргэд
Модны сүүдэрт завилан сууж,
Эсвэл ширэнгэн ой,
Гималайн ууланд
Эсвэл эзгүй цөл,
Хүлын агуй гэх мэтэд залбиран суухдаа,
Аль эсвэл аглаг хийдэд даяанчлан байхдаа
Ариун хутгийг олсон гэж та сонссон байх.
Харин би
Анир шуугиантай амралтын газар,
Арчаа муутайхан ниймлэг майханд
Шөнө дунд унтаж байхдаа
Гэгээрсэн гэдгээ л хэлмээр байна.



Эрт урьдын нэгэн цагт
Энх амьдралыг хүсэгч нэгэн
Өнө мөнхийн жаргалыг эрж,
Өргөн орчлонг самнан бэдэрчээ.
Гараг дэлхийг тойрон явжээ,
Газар усыг туулан гарчээ,
Үүлэн дээгүүр ч нисэн аялжээ,
Наран, сарантойроод иржээ.
Өнөөх мөнхийн аз жаргал нь эцсийн эцэст
Өөрийнх нь сэтгэл зүрхэнд нуугдсан байжээ.
Аз жаргалаа дөнгөж олж аваад
Амсъя уу? гээд тухлан суутал
Яг тээр доор харанхуйд үй олон амьтан
Язганан байхыг гэнэт олж харжээ.
Аанай л өөр шиг нь олон сая жилийн турш
Аз жаргалыг эрэн зовж байгаа юмсанж.

Түүний нулимс аяндаа бөмбөрч эхэлжээ...
Нэг дусал,
Хоёр дусал ...
Бөөн бөөн дусал ... бөмбөрлөө
Дусал бүр нь эрдэнэс болж,
Туяа татан тэнгэрт гэрэлтжээ.
Тэр шигтгээ болсон нулимсан дуслууд
Тэнгэрт түгсэн одод болжээ.
Өдөртөө тэр одод их ичингүйрнэ.
Шөнөдөө ээж цуцахыг үл мэднэ.
Аз жаргалын эрэлчин бүхэнд
Аялах Замыг нь гийгүүлэх гээд,
Гэгээн мэргэдийн хайрыг мэдрүүлэх гэж,
Гэрлээ цацруулаад амсхийх Завгүй.

# Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Зохиол Бүтээлүүд

## Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Шүлгийн цоморлиг




- **Энэ өдөр, тэр өдөр** (Ау Лак хэлээр уншсан шүлгүүд): CD




- **Анхилам сайхныг мэдрэхүй** (Алдарт дуучид Ау Лак хэл дээр дуулсан): CD




- **Үүрд хадгалаарай** (Ау Лак хэл дээр уншсан шүлгүүд): CD




- **T-L-C, гуйя** (Ау Лак хэл дээрх дуу): CD




- **Аятай тавтай амраарай, алдрай мину** (Англи хэл дээр дуулсан дуунууд): CD










- **Хайрын домгийн зам** (Ау Лакын алдарт яруу найрагчдын шүлгүүд, Аулак хэлээр уншсан шүлгүүд): Аудио хуурцаг, CD 1,2 & 3 DVD 1,2










- **Өмнөх амьдралын зам мөр** (Ау Лак хэлээр уншсан шүлгүүд): Аудио хуурцаг, CD 1,2 &3 DVD 1,2 (17 хэлний хадмал орчуулгатай)

**"Хайрын домог туульсад хүрэх зам", "Хаа эртийн хайр", "Цагийн сүүдэр", "Шөнийн зүүд", "Үүрд хадгалаарай", "Энэ өдөр, тэр өдөр", "Өмнөх амьдралын зам мөр", "Эрдэнэсээр чимсэн шүлгүүд", "Алтан лянхуа", "Аятай тавтай амраарай, алдрай мину" болон "T-L-C, гуйя" шүлэг найргуудыг хөгжмийн хэмнэлд оруулж, яруу найрагч өөрөө дуулсан болно. "Аниргүйхэн нулимсыг хайрлахуй" мюзикл, CD&DVD*




• **Цагийн сүүдэр (Цаг хугацаанаас ангид чанагуух ертөнц)** (Ау Лак хэл дээрх дуунууд:) CD ба DVD




• **Хаа эртийн хайр** (Ау Лак хэл дээрх дуунууд): CD ба DVD




• **Шөнийн зүүд** (Ау Лак хэл дээрх дуунууд): CD ба DVD




• **Алтан лянхуа** (Ау Лак хэлээр уншсан шүлгүүд): CD ба DVD Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай эрхэмсэг Thich Man Giac-ийн гайхамшигт шүлгийг болон өөрийн зохиосон “Алтан лянхуа”, “Саёнара” гэсэн шүлгүүдийг уянгалуулан дуудахыг таалан сонсоорой.




• **Эрдэнэсээр хэлхсэн шүлгүүд** (Ау Лакын алдарт яруу найрагчдын шүлгийн Ау Лак хэл дээрх уншилт): CD 1,2; DVD 1,2




• **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өөрөө зохиосон дуу, хөгжимүүд** (Англи, Ау Лак, Хятад хэлээр): CD ба DVD




• **Хайрын дуу** (Англи, Ау Лак хэл дээрх дуунууд): DVD




- **Хайрга ба алт**
  Англи, Ау Лак, Хятад хэл дээр




- **Өмнөх амьдралын зам мөр**
  Англи, Ау Лак, Хятад хэл дээр




- **Эрвээхэйн мөрөөдөл**
  Ау Лак, Хятад, Англи хэл дээр




- **Мартагдсан дурсамж**
  Ау Лак, Хятад, Англи хэл дээр




- **Эрт дээр үе**
  Ау Лак, Хятад, Англи хэл дээр




- **Wu Tzu-н яруу найраг**
  Ау Лак, Хятад, Англи хэл дээр




- **Аниргүйхэн нулимс**
  Их Багшийн шүлгийн ном - Англи/Герман/Франц, Англи/Хятад, Ау Лак, Филиппин,Солонгос, Португаль, Испани хэл дээр




- **Эрин зууны хайр**
  Ау Лак, Хятад, Англи хэл дээр

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ОЮУН САНААНЫ СУРГААЛ, НОМЛОЛУУД

### Номууд

- **Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр**
  Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай-н лекцийн эмхэтгэл. Ау Лак (1-15), Хятад (1-10), Англи (1-5), Франц (1-2), Финн (1), Герман (1-2), Унгар (1), Индонез (1-5), Япон (1-4), Солонгос (1-11), Монгол (1,6), Португаль (1-2), Польш (1-2), Испани (1-3), Швед (1), Тай (1-6), Төвд (1)
- **Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр - Асуулт, хариулт**
  Их Багшийн лекцийн асуулт хариултын эмхэтгэл. Ау Лак (1-4), Хятад (1-3), Болгар, Чех, Англи (1-2), Франц, Герман, Унгар, Индонез (1-3), Япон, Солонгос (1-4), Португаль, Польш, Орос (1)
- **Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр /Долоон өдрийн даяан/ тусгай хэвлэл, 1992 он**
  Англи, Ау лак
- **Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр тусгай хэвлэл / 1993 оны Дэлхийг тойрсон аялал**
  Англи (1-6), Хятад (1-6)
- **Багш шавийн харилцсан захидал**
  Англи (1), Хятад (1-3), Ау Лак (1-2), Испани (1)
- **Их Багшийн гайхамшигт баясахуй:**
  Ау Лак (1-2), Хятад (1-2)
- **Багш үлгэр ярьж байна**
  Англи, Хятад, Испани, Ау Лак, Солонгос, Япон, Тай
- **Бурханых ба хүн төрөлхтнийх - Библийн үлгэрүүдээс**
  Англи, Хятад
- **Бурхан бүгдийг сайтар халамжилдаг - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэргэн ухааны зурагт үлгэрүүд:**
  Ау Лак, Хятад, Англи, Франц, Япон, Солонгос
- **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол –Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**
  Англи, Хятад
- **Амьдралаа өнгөлөг болгохуй**
  Хятад, Англи, Ау Лак
- **Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**
  Хятад, Англи, Ау Лак
- **Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам**
  Англи, Хятад
- **Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ**
  Араб, Ау лак, Болгар, Чех, Хятад, Англи, Франц, Герман, Грек, Унгар, Индонез, Итали, Солонгос, Монгол, Польш, Испани, Түрк, Румын, Орос
- **Алтан эриний үед амьдрахуй**
  **Эрүүл мэндийг ухаарахуй – Амьдралын жам ёсны бөгөөд зөв замд буцаж орох нь**
  Хятад, Англи
- **Онч мэргэн үг**
  Англи/Хятад, Испани/Португаль, Франц/Герман хоёр хэлээр, Солонгос

• **Тэнгэрлиг зоог** (1) - Олон улсын цагаан хоолны гал тогоо:
Англи/Хятад хэлээр, Ау Лак, Япон

• **Тэнгэрлиг зоог** (2) - Гэрийн хоолны амтат сонголт
Англи/ Хятад

• **Ая эгшигээр амгалан дэлхийг бүтээхүй**
Англи/ Ау Лак / Хятад

• **SM Тэнгэрийн хувцас**
Англи/ Хятад

• **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлиг**
Англи, Хятад

• **Миний амьдрал дахь ноход**
Ау Лак, Хятад, Англи, Япон, Солонгос, Испани, Польш, Герман

• **Шувууд миний амьдралд**
Ау Лак, Хятад, Англи, Франц, Герман, Солонгос, Монгол, Орос, Индонез

• **Эрхэм ариун амьтад**
Ау Лак, Хятад, Англи, Франц, Герман

• **Тэнгэрийн урлаг**
Англи, Хятад

• **Жинхэнэ хайр**
Англи, Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекц, хөгжим, концертын аудио, видео хуурцгууд, MP3, CD, DVD –үүд Араб, Армени, Ау Лак, Болгар, Камбож, Кантонез, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Мандарин, Монгол, Непал, Норвеги, Перс, Польш, Португаль, Румын, Орос, Сингал, Словак, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэл дээр хэвлэгдсэн байдаг. Таны хүсэлт тавьсны дагуу жагсаалтыг илгээх болно. Асууж лавлах зүйл байвал чөлөөтэй хандана уу. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн үеийн ном хэвлэлийн товч мэдээ, жагсаалтыг татаж авах хүсэлтэй бол манай номын дэлгүүрийн вэб хаягаар зочлоорой: http://www.smchbooks.com/ (Англи ба Хятад хэлээр буй.)

**ЗАХИАЛАХ ХАЯГУУД:**
http://www.theCelestialShop.com http://www.EdenRules.com

**ЭСВЭЛ ДАРААХ ХАЯГААР ХОЛБОО БАРИНА УУ**:
Tel: (886) 2-23759688 / Fax: (886) 2-23757689
E-mail: smchbooks@Godsdirectcontact.org

**ROC Postal Remittance Account No.: 19259438**
(Зөвхөн Формосагийн захиалга)

**Илгээмжийн хаяг:**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн хэвлэлийн компани, ХХК

## АГШИН ЗУУР БИЛЭГ НЭЭГДЭХҮЙН ТҮЛХҮҮР
## - ҮНЭГҮЙ ТАРААГДАХ ТОВХИМОЛ

“Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр” товхимол ном нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургаалийн товч тайлал юм. Энэхүү товхимол цахим хэлбэрээр бэлэн байдаг учраас интернет хаягаар орж үнэ төлбөргүй татан авч, унших боломж дэлхий дахины уншигчдад олгогддог. Африкийн Зулу хэлээс авахуулаад, Бенгали, Урду, Македони, Малай болон бусад олон хэлнээ буюу 74 хэл дээр орчуулагджээ.

Энэ товхимолд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өдөр тутмын амьдралд бясалгал чухал болохыг онцлон тайлбарладаг. Түүнчлэн оюун санааны дээд ертөнцүүд, веган хоолны ач тус, Гуань Инь аргын бясалгалаар авшиг хүртэхүй, оюун санааны хамгийн дээд эцсийн замналын талаар түүний айлдварууд багтсан буй. “*Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр*” товхимолд өгүүлэгдсэн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэргэн оюун билэг Үнэнийг эрэгчдийн цангааг тайлж, гэгээн итгэлийг бэлэглэдэг юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай “Дотоод дахь амар амгаланд хүрвэл бидэнд бүх юм буй болно. Сэтгэл ханамж, хорвоогийн хийгээд тэнгэрлиг бүх хүсэл Бурханы хаант улсаас тэтгэгдэн бүтэж, дотооддоо мөнхийн эе зохирол, мөнх билэг ухаан, бүхнийг чадагч хүчээ бид ухааран таних болно. Хэрвээ бид үүнийг өөртөө олж авахгүй бол ямар ч хөрөнгө мөнгө, эрх мэдэл, албан тушаал байлаа гээд хэзээ ч сэтгэл ханамжийг олж үл чадна” хэмээн айлдсан билээ.

**Товхимлыг дараах хаягаар аваарай:**
http://sb.godsdirectcontact.net/
Энэ вэб хаягт Их Багшийн товхимол олон хэл дээр буй. Бурханы илгээлтийг хуваалцаж, хүний ухамсрыг дэвшүүлэх замаар дэлхийдээ хамгийн сайхан бэлгийг барихад бидэнтэй нэгдэгтүн. Хэрвээ таны төрөлх буюу анхдагч хэл манай жагсаалтанд байхгүй байвал, мөн та Товхимлыг дуртай хэл рүүгээ орчуулъя гэвэл дараах хаягаар бидэнд хандаарай: divine@Godsdirectcontact.org.

**Товхимлыг үнэгүй татаж авах хаяг:**
http://sb.godsdirectcontact.net (Formosa) (U.S.A.)
http://www.direkter-kontakt-mit-gott.org/download/index.htm (Austria)

*Шар : Шар арьстан хүмүүс*
*Улаан: Улаан арьстан хүмүүс*
*Хар: Хар арьстан хүмүүс*
*Цагаан: Цагаан арьстан хүмүүс*
*Ногоон : Байгаль, амьтад, шувууд гэх мэтийг ...*
*Цэнхэр: Ус, усны амьтад*
*Дүрс: Дэлхий*
*Дэвсгэр: Тэнгэр*



*Далбаан дээрхи SM Лого нь бидний Бурханлиг чанарыг сэрээж, бидэнд дотоод дахь ялгуусан чанараа хөгжүүлэхийг сануулах зорилготой. Хоёр талд байх хоорондоо хэлхээтэй янз бүрийн өнгөт зүрхэн дүрсүүд нь Бурхан дэлхий дээрхи хамаг амьтнаас юу хүсэн хүлээдгийг бэлгэддэг бөгөөд тэр нь бүхий л ялгаварлан гадуурхал эцэслэгдэж, хамаг төрөлтөн бүгдээр хайрлагдан халамжлагдаж, энх амгалан, баяр хөөр цэнхэр тэнгэрийн дор цогцлохуйн тухайд юм.*

ЭНЭХҮҮ ГАЙХАМШИГТ, УТГА ТӨГС ДАЛБААНЫ ЗАГВАРЫГ БАГШ МААНЬ БИДЭНД ЗОРИУЛАН ЗОХИОМЖИЛСОН БОЛНО. ӨНГӨ БУДАГ, ХЭЛБЭР ДҮРСИЙН НИЙЛЭМЖИЙГ Ч ТЭРБЭЭР ТАЙЛБАРЛАН ОЙЛГУУЛСАН БИЛЭЭ.

## *Бидэнтэй холбоо барих хаяг*


**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг**
P.O. Box 9, Hsihu, Miaoli, Formosa, R.O.C. (36899)
P.O. Box 730247, San Jose, CA 95173-0247, USA

**Суприм Мастер Телевиз**
Email: pease@SupremeMasterTV.com
http://www.SupremeMasterTV.com/
Tel: 1-626-444-4385 / Fax: 1-626-444-4386
Хиймэл дагуулын тухай дэлгэрэнгүй мэдээлэл:
http://suprememastertv.com/satellite

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн компани, Тайпэй, Формоса**
Email: smchbooks@Godsdirectcontact.org
http://www.smchbooks.com
Tel: (886) 2-23759688 / Fax: (886) 2-23757689

**Номын хэлтэс**
Email: divine@Godsdirectcontact.org
(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн номнуудыг орчуулах ажилд та оролцох боломжтой)

**Мэдээний алба**
Email: lovenews@Godsdirectcontact.org

**Бясалгалын мэдээлэл өгөх**
Email: lovewish@Godsdirectcontact.org

**Онлайн дэлгүүр**
Celestial Shop: http://www.theCelestialShop.com (English)
Eden Rules: http://www.edenrules.com (Chinese)

**S.M. Celestial Co., Ltd.**
Email: smclothes123@gmail.com; vegan999@hotmail.com
http://www.sm-celestial.com http://www.smcelestial.com
Tel: 886-3-4601391 / Fax: 886-3-4602857

**Loving Hut Олон Улсын компани ХХК**
Email: service@lovinghut.com
http://www.lovinghut.com/tw/
Tel: 886-3-4683345 / Fax: 886-3-4681581

**Хайрын хүнс – Онлайн дэлгүүр**
**Эрүүл веган аж төрөхүйд зориулав.**
http://www.lovingfood.com.tw

**Гуань Инь Вэб хаяг**
Бурхантай шууд холбогдох - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгийн интернет хаяг:
http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm

# *Аниргүйхэн нулимс*

ЗОХИОГЧ
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

МОНГОЛ ХЭЛНЭЭ ХӨРВҮҮЛСЭН
Жалбуугийн Чойнхор

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН
Пүрэвийн Бадрал, Лувсандоржийн Билгүүнтөгс,
Батчулууны Ундрах

ХЭВЛЭЛИЙН ЭХИЙГ БЭЛТГЭСЭН
Дисдаабазарын Буян-Өлзий

The SMCHIA Book Department
Binh Q. Diep

ХЭВЛЭГЧ
The Supreme Master Ching Hai
International Association Publishing Co., Ltd.
Rm. 16, 8F., No.72, Sec. 1, Zhongxiao W. Rd.,
Zhongzheng Dist., Taipei City.100, Taipei, Formosa(Taiwan), R.O.C.
E-mail: smchbooks@Godsdirectcontact.org
Tel: 886-2-23759688
Fax: 886-2-23757689

ХЭВЛЭЛ
Анхны хэвлэл
2015 оны 4-р сар

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1988~2015
ISBN: 978-99962-4-383-7
Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Хэвлэгчээс урьдчилан зөвшөөрөл авсны дагуу та энэ
номын яруу найргуудыг дахин хэвлэж болно.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүүхэд насаасаа л шүлэг бичдэг авьяаслаг найрагч байлаа. Тэрээр долоон настай байхдаа шүлэг бичиж эхэлсэн юм. Их Багшийн маань шүлэг найраг нягтлан тунгаасан, баян тансаг бөгөөд хөгжилтэй байдаг нь уншигчдын зүрх сэтгэлийг хөдөлгөж унших хүслийг нь улам бүр төрүүлдэг ажээ. Их Багш Чин Хай шүлэг найргийн анхны түүврээ Ау Лакт дунд сургуульд сурч байхдаа хэвлүүлж байжээ. Тэр үед Ау Лакийн Ерөнхий сайд сайшаан дэмжиж, өөрийнхөө дуртай яруу найргийн номыг Чин Хай багшид дурсган өгчээ. Чин Хай багшийн зарим нэг шүлгэнд нэрд гарсан хөгжмийн зохиолчид ая зохиосноос гадна нэлээд шүлэг нь Ау Лак хэлээр олон сонин сэтгүүлд нийтлэгдсэн байна.

Энэхүү ном нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай гэгээрлийг эрэлхийлэн хэцүү бэрхийг туулж явах он жилүүддээ бичсэн шүлэг найргийн түүвэр юм.Үнэнд хүрэх цорын ганц замаар яваа бясалгагч нөхдөө урамшуулан зоригжуулахыг хүссэн нэгэн чин бишрэлт шавийнхаа хүсэлтээр энэхүү номыг хэвлүүлсэн ажээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай маань нэгэн насандаа агшин зуур гэгээрэн, хорвоогийн хүлээснээс чөлөөлөгдөж болох бясалгалын Гуань Инь аргыг дэлхийг тойрон айлдсаар явнам.

8658000637133

